

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН САН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Э.Хулан миний
2024 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024.05.31

Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд тэтгэмж, ажилгүйдэл, ҮОМШӨ даатгалын сангийн тайланг хуулийн хугацаанд гаргаж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав.

Нэг. Нийгмийн даатгалын сангийн санхүү бүртгэлийн хүрээнд

1. Монгол улсын Сангийн сайдын 2006 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18/03 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн тушаалаар баталсан нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

2. Анхан шатны баримтыг үндэслэн ажил олгогч, даатгуулагчдын Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкны 6 дансаар данс андуурсан гүйлгээг буцаан шилжүүлж, дансны хуулга, үлдэгдлийг тулган нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэн ажиллав.

Хоёр. Банкнуудаар хийгдсэн сангийн орлого зарлагын гүйлгээний талаар:

1. Монгол улсын Сангийн сайд, Хөдөлмөр Нийгэм хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246/А/245 тоот хамтарсан тушаалаар баталсан “Маягт журам батлах тухай”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/65 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг тус тус мөрдлөг болгон баримтлан ажиллаж байна.

2. Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкаар орж ирсэн сайн дурын болон ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээллийг банкны хуулгатай тулган төвлөрсөн харилцахын мэдээллийн санг бүрдүүлсэн.

3. Нэр, регистр тодорхойгүй 315 гүйлгээг банкны данс эзэмшигчийн жагсаалт болон мэдээллийн сангаас олох, банкинд жагсаалт хүргүүлэн мэдээлэл солилцох ажлын хүрээнд 375,2 сая төгрөгийг ажил олгогч ба даатгуулагчийн нэр дээр залруулан бүртгэж мэдээллийн санг үнэн зөв болголоо.

4. Арилжааны банкаар гаргаж буй гүйлгээг батлагдсан журмын дагуу бүртгэлтэй Email хаягаараа дамжуулан хийж байна. НДЕГ-тай байгуулсан арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу эхний хагас жилийн гэрээг дүгнэн ажиллалаа.

№	Банк	Гүйлгээний тоо /сарын дундаж/	Орлогын дүн /сая төгрөгөөр/	Зарлагын дүн /сая төгрөгөөр/
1	Төрийн сан	604	31,6	31,6
2	Төрийн банк	26140	42987.2	42987.2
3	Төрийн банк /ЭМД/	37	2,0	2,0
4	Худалдаа хөгжлийн банк	1711	71983.5	71983.5
5	Капитрон	2957	19355.9	19355.9
6	Капитрон /ЭМД/	45	3,2	3,2
7	Хаан	27893	91735.2	91735.2
8	Голомт	2434	47623.3	47623.3
Нийт дүн		37664	335296	335296

6. 2024/01/04 -ны НДЕГ-н 01/28 тоот тушаалын дугаарын дагуу данс хааж Арилжааны банкны 3 данс, Төрийн сангийн 1 данс нийт дөрвөн дансны 6,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж ажиллав. Данс хаахтай холбоотойгоор НДЕГ-ын Ахлах мэргэжилтэн Б.Ариунтуяа ЧДНДГ-с Сан хариуцсан мэргэжилтэн Э.Хулан СБТДарга бөгөөд ахлах ня-бо Г.Жавзандулам нарын бүрэлдэхүүнтэй 2,3 сая төгрөгийн ЭМД-ын дансанд 2023 ба түүнээс өмнөх онуудад датгуулагчийн төлсөн шимтгэлийг 3303-аар бүртгэснийг тооцоо нийлсэн акт үйлдэж ажилласан.

7. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд арилжааны банкнуудаас ирсэн төвлөрсөн сангийн хуулгыг үнэн зөв бүртгэж, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-ны өдөр цаг хугацаанд нь үнэн зөв гарган цахимаар хүргэн ажиллав.

8. Илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг даатгуулагч тус бүрээр хянаж, 20 хүнд 53,8 сая төгрөгийн буцаан олголтыг олгож, холбогдох дансдуудад хуваарилалт хийсэн.

9. Байгууллагын нэр регистр зөрсөн 252,4 сая төгрөгийн гүйлгээг утасны дугаар, дансыг ашиглан холбогдон залруулж өглөг, авлага гаргахгүй байх тал дээр анхааран ажиллалаа.

Гурав. Төвлөрүүлэлтийн ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 02 сарын 01-ны өдрийн 05/777 тоот Төвлөрсөн харилцахаас нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг "Нийгмийн даатгалын ерөнхий газрны даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Журам батлах тухай" А/183 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь хэсэгт заасан гүйлгээг арилжааны банктай "Хамтран ажиллах гэрээ"-нд өөрчлөлт орох хүртэл хугацаанд төлбөрийн даалгавраар гүйлгээг хийх гэж заасны дагуу өдөр бүр төвлөрүүлэлт хийдэг. 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 200001,5 саяын орлогыг НДЕГ-ын төвлөрсөн санд төвлөрүүлэн ажилласан.

Дөрөв. Сангийн бусад өглөг (3303 тоот данс)

Бусад өглөг /3303/ дансанд бүртгэгдсэн байгууллагын нэр, регистр тодорхойгүй гүйлгээнүүдийн жагсаалтыг харилцагч банкуудад EXCEL-ээр гаргаж хүргүүлэн нэр тодорхойгүй ажил олгогч даатгуулагчийн регистрийн дугаар, ажил олгогчийн код, утасны дугаар зэрэг мэдээлэл солилцох, даатгуулагч иргэдтэй утсаар холбогдож тухайн үед харилцах дансанд НДШ-ийн болон СДД-ийн шимтгэл төлсөн банкны хуулга, холбогдох баримтуудыг авч гүйлгээнүүдийг залруулан ажиллаж байна.

Тав. SICOS ПРОГРАММЫН ТАЛААР

Нэгжид шинээр ашиглагдаж буй <https://sicos.ndaatgal.mn> программд шилжсэнээр 2024 оны 1сараас 5сар дуустал зургаан банкны төвлөрсөн орлогыг өдөр бүр банкны хуулгаас форматын дагуу excel программд хөрвүүлж /зургаан банкны нэг өдрийн дундаж гүйлгээ:953/ нийт нэг бүрчлэн шалган,гараар таниулж ажилласан. Ажил олгогч СДД-ын ндш төлөлтийг УОО бүртгэх явцад РД-р харилцагчийг танихгүй алдаа гарахад НДЕГ-н ахлах мэргэжилтэн Б.Ариунтуяад жагсаалтаар явуулж мөн хариуцсан байцаагч нарт мэдэгдэж цаг тухайд нь арга хэмжээ авж ажилласан. НДЕГ-ын жагсаалтаар ирүүлсэн салбар зөрсөн ажил олгогч нарын ндш-ийн төлөлтийг залруулж, дүүрэг солигдож байгаа байгууллагуудтай тооцоо нийлж илүү болон дутуу төлөлийг төлүүлж ажилласан.

Зургаа. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Газрын даргын 2022 оны А/59 тоот тушаалаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавих ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн мэдээ, мэдээллийг байршуулах, олон нийтэд хүргэх, сайтанд байршуулсан мэдээллийг хянах, ажлын дүн мэдээг гаргах зэргээр шинэчлэн баталсан. Шилэн дансны мэдээ, мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан үндэслэлээр 2023 оны тайлангаар аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.


2024 оны эхнээс шилэн дансны сайт шинэчлэгдсэн бөгөөд таван саяаас дээш орлого зарлагын гүйлгээ сар болгоны 8-ны холбогдох форматын дагуу бэлтгэж www.shilendans.gov.mn сайтад байршуулан нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллаж байна.

Долоо. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД



Тус газар нь нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, сургалтын файл хичээлүүдийг албан хаагчдад тараан өгч, бие даан судлуулсан.



2024 оны 03 дугаар сарын 20-ний өдөр "Захирамжлахыг баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, Абле edoc системд хөрвүүлэх нь" сэдэвт сургалтад цахимаар архивын ажилтан Х.Даваажаргал, Б.Болорчимэг нар хамрагдаж газрын албан хаагчдад архив албан хэргийн сургалтыг зохион байгуулж ажилласан.



Сургалтын төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулгын талаар сургалтыг нийт байцаагч ажилтан албан хаагчдад Үйлчилгээний тасгийн дарга З.Мөнхнаран удирдан зохион байгуулж ажилласан. Сургалтаар хуулийн хэрэгжилт болон тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хөтлөн явууллаа.




Сургалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулгын талаар сургалтыг нийт байцаагч ажилтан албан хаагчдад 7 хоног бүр тасаг тасгаараа хувааж зохион байгуулж ажилласан. Сургалтаар хуулийн хэрэгжилт болон тэтгэвэр тэтгэмж, хамралт, сайн дурын даатгалтай холбоотой нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад сургалтыг хөтлөн явууллаа.

"Хүний хөгжил-Нийгмийн баталгаа -2024" арга хэмжээ батлах тухай 32 дугаар тогтоолын хүрээнд ажилтан албан хаагчдад мэдлэг мэдээлэл олгох, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор "Эрүүл дадлыг бүтээцгээе"сэдэвт сургалтыг сургагч багш М.Баярцэцэг удирдан явуулж эрүүл зөв хооллолтын талаар сургалт мэдээллийг хүргэж ажилласан.



Монголын бүтээмжийн төв нь 2024 оны 03 сарын 22 өдөр бүтээмжийн зөвлөлийн гишүүдэд зориулан "Чанарын дугуйлан гэж юу вэ, ЧД-г хэрхэн хэрэгжүүлэх, түүний ач холбогдол, ЧД-аар дамжуулан байгууллагын бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар ойлголт өгөх, чиглүүлэг" сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтаар "ЧД-ийн гишүүдийн зохион байгуулалтыг танилцуулах, чанарын дугуйлангийн ойлголт ба зарчмын тухай, байгууллагад ЧД-г хэрэгжүүлэх менежмент арга, чанарын хяналтын үндсэн 7 арга, мөн багын ажиллагаа зохион байгуулж заавар зөвлөгөө өглөө.



Тохижилт-Бүтээн байгуулалтыг дэмжих жил"-ийн хүрээнд хаврын ээлжит бүх нийтийн мод тарих өдрөөр байгууллагын ажилтан албан хаагчдын оролцоог хангаж "Хайрхан хөгжлийн төв"-д газрын нэрэмжит төгөл байгуулж нийт 93 ширхэг модыг тарьж усалгааг хийж ажиллагаа. Улиас нийт 50 ширхэг, Хар мод 10 ширхэг, гацуур 2 ширхэг, үхрийн нүд жимст мод 10 ширхэг, тэхийн шийг 10 ширхэг, нохойн хошуу 10 ширхэг, хус мод 1 ширхэг модыг тарьж, 14 хоног дугтамд хувиар гарган 2 албан хаагч очиж усалж ажиллахаар болсон.






Мөн газрын албан хаагчид өрөө тасалгааны тохижилтод анхаарч цэцэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж 1-3 давхарт цэцэгжүүлэлтийг хийж ажиллалаа.

Өмнө нь




Одоо



Өмнө нь



Одоо



Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2024 оны "Бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай" А/01 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, халтирч унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Их цэвэрлэгээ 90 минут" бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай удирдамжийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр, 2-2, 3-22, 4-27-ны өдрүүдэд бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, газрын өөрийн байр болон Хайлааст дахь тасгийн байрны ойр орчмын 50 м хүртэлх талбайг цэвэрлэн, хог хаягдлыг түүж, хогийн цэг рүү ачуулж, ажиллалаа.



Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн "Хаврын их цэвэрлэгээ нэгдсэн араг хэмжээ" зохион байгуулах тухай А/348 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хотоо угаая" аяны хүрээнд иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Их цэвэрлэгээ" бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 17:00-19:30 цагийн хооронд зохион байгуулж, газрын өөрийн байр болон Хайлааст дахь тасгийн байрны ойр орчмын 50 м хүртэлх талбайг цэвэрлэн, угааж, хог хаягдлыг түүж, хогийн цэг рүү ачуулж, ажиллалаа.



ТАЙЛАН БИЧСЭН:

Хулан

/ Э.Хулан/